

ЗӨВШӨӨРӨВ:
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ТӨРИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА,
ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ
ХӨГЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

..... Д.ОЧИРБАТ



БАТЛАВ:
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ДЭРГЭДЭХ
НҮҮР АМНЫ МЭРГЭЖЛИЙН САЛБАР
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

..... Б.БАЯРЧИМЭГ



ШҮДНИЙ ЭМЧИЙН
“ХҮҮХДИЙН НҮҮР АМ СУДЛАЛ”
ҮНДСЭН МЭРГЭШЛИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

ИНДЕКС: S(r) 091104
ХУГАЦАА: 2 жил

УЛААНБААТАР ХОТ
2024 ОН

БОЛОВСРУУЛСАН АЖЛЫН ХЭСЭГ

Ж.Дэлгэрцэцэг	Хүүхдийн нүүр ам судлал, урьдчилан сэргийлэлтийн тэнхимийн ахлах багш, Анагаах ухааны доктор
М.Ичинхорлоо	Нүүр ам судлалын салбар зөвлөлийн гишүүн, Энэрэл дент эмнэлгийн захирал, Анагаах ухааны магистр

ХАМТРАН АЖИЛЛАСАН:

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн төлөөлөл:

Б.Оюунцэцэг	Хүүхдийн нүүр ам судлал, урьдчилан сэргийлэлтийн тэнхимийн профессор, Анагаах ухааны доктор, профессор
Ш.Мөнх-Од	Хүүхдийн нүүр ам судлал, урьдчилан сэргийлэлтийн тэнхимийн ахлах багш, Анагаах ухааны магистр
Б.Цэлмэг	Хүүхдийн нүүр ам судлал, урьдчилан сэргийлэлтийн тэнхимийн эрхлэгч, Анагаах ухааны доктор
А.Сувданчимэг	Хүүхдийн нүүр ам судлал, урьдчилан сэргийлэлтийн тэнхимийн багш, Анагаах ухааны магистр
Г.Номин	Хүүхдийн нүүр ам судлал, урьдчилан сэргийлэлтийн тэнхимийн дадлагажигч багш, Анагаах ухааны магистр
Б.Баярмаа	Хүүхдийн нүүр ам судлал, урьдчилан сэргийлэлтийн тэнхимийн дадлагажигч багш, Анагаах ухааны магистр

Мэргэжлийн нийгэмлэг холбоодын төлөөлөл

Б.Оюунцэцэг	Монголын хүүхдийн нүүр ам судлал, урьдчилан сэргийлэлтийн холбооны тэргүүн, Анагаах ухааны доктор, профессор
-------------	--

ХЯНАСАН:

Н.Дашдондов	Эрүүл мэндийн яамны Стратеги төлөвлөлтийн газрын Салбарын хүний нөөцийн хөгжлийн хэлтсийн Салбарын хүний нөөцийн сургалт, мэргэшлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн асуудал хариуцсан мэргэжилтэн
Д.Дондогмаа	Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Хүний нөөцийн хөгжлийн албаны үндсэн мэргэшлийн сургалт хариуцсан ахлах мэргэжилтэн

**ШҮДНИЙ ЭМЧИЙН “ХҮҮХДИЙН НҮҮР АМ СУДЛАЛ”
ҮНДСЭН МЭРГЭШЛИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР**

НЭГ. ҮНДЭСЛЭЛ

Нүүр ам судлалын салбарын бие даасан нэг салбар болох Хүүхдийн нүүр ам судлал нь сүүлийн жилүүдэд эрчимтэй хөгжиж байна. Манай улсын хүн ам зүйн сүүлийн таван жилийн статистик мэдээнээс харвал нийт хүн амын 50 хувийг 18 нас хүртлэх насны хүүхэд эзэлж байна. Харин хүүхэд, өсвөр үеийнхний дунд амны хөндийн зонхилон тохиолдох эмгэгийг шүд цоорох өвчин түүний хүндрэл тэргүүлж байгаа ба 10 хүүхэд тутмын 9 нь уг өвчинд өртсөн байна. Хүүхэд насанд үүссэн шүд цоорох өвчин нь хүүхдийн эрүү нүүр, амны хөндийн эрхтнүүдийн хэвийн өсөлт хөгжилт төдийгүй бие махбодын эрүүл мэндийн байдалд сөргөөр нөлөөлж байна. Нөгөө талаас хүүхдийг хүрээлж буй нийгмийн өөрчлөлт нь хүүхдийн эрүүл мэндэд нөлөөлөхийн хамт, сүүн шүдний шүд цоорох өвчин, түүний хүндрэл нь шүд эрүү нүүрний хэвийн хоршилт, зуулт төлөвшихөд шууд нөлөөлж, шүд шүдний эгнээний гажиг үүсэх үндсэн нөхцөл суурь болдог. Мөн хүүхдийн шүдний эмчилгээ нь хүүхдийн нас сэтгэхүйн онцлогоос хамааран нилээд нарийн түвэгтэй, айдас түгшүүртэй, хүндрэл эрсдэл үүсэх нөхцөл бүхий байдалд явагддагаас цаг алдах, хүндрэх тохиолдол өндөр байдаг.

Өнөө үед нүүр ам судлалын практикт хүүхдийн нүүр амны өвчний эмчилгээ, урьдчилан сэргийлэлтийн асуудал болон хүүхдийн нүүр амны тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах асуудал нэн чухлаар тавигдаж байна. Иймээс хүүхдийг бие махбодын болон шүд эрүү нүүрний эрхтний өсөлт хөгжилтийн үед нь тэдний нас сэтгэхүйн онцлогт тохируулан харилцаж, сэтгэл зүй зан төлөвийг нь зөв залах замаар урьдчилан сэргийлэлт, оношилгоо, эмчилгээг цогц байдлаар гүйцэтгэх өндөр чадвар бүхий хүүхдийн нүүр амны эмчийг бэлтгэхийн тулд хүүхдийн нүүр ам судлалын үндсэн мэргэшлийн сургалтын цөм хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах зайлшгүй шаардлагатай байна. Өнөөдрийн байдлаар “Хүүхдийн нүүр ам судлал”-ын чиглэлээр нарийн мэргэшил эзэмшсэн эмнэлгийн мэргэжилтний тоог нийт хүүхдийн тоотой харьцуулахад нэг эмчид хорин мянга гаруй хүүхэд оногдож байгаа нь олон улсын жишигтэй харьцуулахад даруй арав дахин өндөр үзүүлэлт юм. Энэ нь нийгэмд “Хүүхдийн нүүр ам судлал”-ын нарийн мэргэшлийн эмчийн тоог хангалттай хэмжээнд хүргэж нэмэгдүүлэх шаардлагатайг батлан харуулж байна.

Мэргэжлийн өндөр ур чадвартай, хүнлэг энэрэнгүй сэтгэлтэй, орчин үеийн анагаах ухаан, хүүхдийн анагаах ухаан, хүүхдийн нүүр ам судлалын хөгжлийн чиг хандлагад нийцэхүйц нарийн мэргэжлийн хүүхдийн нүүр амны эмч бэлтгэх зайлшгүй шаардлагатай байна.

ХОЁР. ЭРХЭМ ЗОРИЛГО

Хүүхдийн шүд эрүү нүүрний эрхтний өсөлт хөгжилтийн үед нь тэдний нас сэтгэхүйн онцлогт тохируулан харилцах, сэтгэл зүй зан төлөвийг нь зөв залах замаар хүүхдийн шүд эрүү нүүрний өвчин эмгэгийн урьдчилан сэргийлэлт, оношилгоо,

эмчилгээний онол-эмнэлзүйн өндөр мэдлэгтэй, хүүхдийн нүүр амны өвчин эмгэгийн үеийн яаралтай ба нарийн мэргэжлийн тусламжийг эрүүл мэндийн тусламж үйлчилгээний бүх түвшинд үзүүлэх эмнэлзүйн чадвартай, бүх шатлалын эмнэлэгт ажиллах чадвартай хүүхдийн нүүр ам судлаач эмчийг боловсролын үндсэн зарчим, олон улсын жишиг хандлагад нийцүүлэн бэлтгэхэд сургалтын зорилго оршино.

ГУРАВ. АЛСЫН ХАРАА

Эмч хүний мэргэжлийн хариуцлагыг бүрэн ухамсарласан, үйлчлүүлэгчийн эрх, эмчийн ёс зүйг дээдлэн ажилладаг, урьдчилан сэргийлэх, оношлох, эмчлэх онолын өндөр мэдлэгтэй, эрдэм шинжилгээ, судалгаа, нотолгоонд суурилсан, инноваци бүхий мэргэжлийн ур чадварыг эзэмшсэн мэргэжилтэн байна.

ДӨРӨВ. ЦОГЦ ЧАДАМЖ

Чадамж бүхий эмч болохын тулд дараах дэд чадамжийг эзэмшиж, мэргэжлийн тусламж үйлчилгээг бие даан гүйцэтгэж чаддаг болно. Үүнд:

1. Хүүхдийн нүүр ам судлаач эмч байх (Pediatric dentistry)
2. Мэргэжлийн байх (Professional)
3. Суралцагч байх (Learner)
4. Харилцагч байх (Communicator)
5. Хамтрагч байх (Collaborator)
6. Эрүүл мэндийн зөвлөгч байх (Community health advocate)
7. Зохион байгуулагч, манлайлагч байх (Leader)

ТАВ. СУРГАЛТЫН ЗОРИЛГО

Хөтөлбөр нь доорх зорилтыг ханган биелүүлнэ:

1. Хүүхдийн нүүр ам судлаач эмч байх (Pediatric dentistry)

- Хүүхдийн нүүр ам, шүд эрүү нүүрний эрхтнүүдийн эмгэгийн шинж тэмдгийг таньж, ялган оношлох
- Үйлчлүүлэгч хүүхэд, тэдний асран хамгаалагчаас асуумж авах, мэргэжлийн үзлэг хийх, хүүхдийн сэтгэлзүй, нөхцөл байдлыг үнэлж оношилгоо, эмчилгээ, хяналтын төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх
- Тухайн эмч өөрийн ажиллаж буй эмнэлгийн (орон нутаг, дүүргийн эмнэлэг, төрөлжсөн, нэгдсэн, клиник) төвшинд хийгдэх оношилгоо, эмчилгээний гардан үйлдэл, ажилбарын стандарт удирдамжийг бүрэн эзэмшиж, тусламж үйлчилгээг аюулгүй үзүүлэх
- Үйлчлүүлэгч хүүхдийн хувийн нууцыг хадгалах
- Үйлчлүүлэгч хүүхдийн өвдөлт, сэтгэл зовнилд анхаарал хандуулах
- Тухайн эрүүл мэндийн байгууллагын тусламж үйлчилгээний нөөц бололцоог бүрэн дайчилж үйлчлүүлэгчид үзүүлэх мэргэжлийн тусламж үйлчилгээг шийдвэрлэх
- Эрүүл мэндийн байгууллагын бүртгэл, тайлан, бичиг баримтыг зохих журмын дагуу цаг тухайд нь хөтлөх

2. Мэргэжлийн байх (Professional)

- Хүүхдийн нүүр ам судлалын бусад салбар шинжлэх ухааны өндөр мэдлэгтэй, тухайн эрүүл мэндийн байгууллагад өөрийн мэргэжлээр хувь нэмэр оруулах чин хүсэл эрмэлзэлтэй байх
- Үйлчлүүлэгч хүүхдийг хувь хүний хувьд хүндэлж, хамгийн оновчтой зөв шийдвэр гаргахын төлөө ажиллах
- Хувь хүний онцлогийг харгалзан үйлчлүүлэгч хүүхэд болон тэдний асран хамгаалагч, гэр бүл, төрөл садантай хүндэтгэлтэй харилцах

3. Суралцагч байх (Learner)

- Өөрийн мэдлэг ур чадвараа дээшлүүлэхийн тулд хэрэгцээт сургалтад байнга хамрагдах
- Өдөр тутам шинэчлэгдэж байгаа анагаах ухааны дэвшлээс хоцрохгүйн тулд бие даан тасралтгүйгээр суралцах, олон төрлийн мэдээллийн эх үүсвэрийг судлах, дүн шинжилгээ хийх
- Хамтран суралцагч эмч, эмнэлгийн бусад мэргэжилтэнд заах замаар өөрийн мэдлэг ур чадвараа сайжруулах

4. Харилцагч байх (Communicator)

- Үйлчлүүлэгч хүүхэд болон тэдний асран хамгаалагч, гэр бүл, төрөл садны хүнтэй зүй зохистой үг хэллэг ашиглан зөв боловсон харилцах
- Үйлчлүүлэгч хүүхэд болон тэдний асран хамгаалагчид шаардлагатай мэдээлэл өгөхдөө ойлгоход хялбар үг хэллэг ашиглан тайлбарлах
- Шаардлагатай тохиолдолд өвчтөний оношилгоо, эмчилгээний талаар эмнэлгийн бусад мэргэжилтэнтэй зөвлөлдөх

5. Хамтрагч байх (Collaborator)

- Тухайн орон нутгийн болон үйлчлэх хүрээний эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбоотой асуудлаар мэргэшлийн эмч нартай мэдээлэл солилцох, хамтран ажиллах
- Эмнэлгийн бусад тасгийн эмч, эмнэлгийн мэргэжилтэнтэй мэргэжлийн мэдлэг мэдээллээ хуваалцаж хамтран ажиллах

6. Эрүүл мэндийн зөвлөгч байх (Community health advocate)

- Хүн амын эрүүл мэндийн зөвлөгч байхын тулд урьдчилан сэргийлэх, тусламж үйлчилгээ үзүүлэх, сургалт сурталчилгаа явуулах
- Хүн амын эрүүл мэндийн хэрэгцээнд тохирсон арга хэмжээг авч хэрэгжүүлэх

7. Зохион байгуулагч, манлайлагч байх (Leader)

- Мэргэжлийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг зохицуулах, манлайлан ажиллах үүргээ ухамсарлах

ЗУРГАА. СУРГАЛТЫН АРГА ЗҮЙ

6.1. Сургалтын чиглэл, хугацаа, байршил

- Сургалт үргэлжлэх нийт хугацаа 2 жил буюу 88 долоо хоног байна.
- Эрүүл мэндийн яамны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн шийдвэрээр “Нүүр амны мэс засал судлал” үндсэн мэргэшлийн сургалт эрхлэх зөвшөөрөл олгогдсон эрүүл мэндийн байгууллага нь энэхүү сургалт явуулах үндсэн байгууллага байна.

- Хөтөлбөрийн зарим агуулгын явуулах хангалттай орчин бүрдүүгүй тохиолдолд мэргэжлийн хичээлийн тойролтуудын 30 хүртэлх хувийг эрүүл мэндийн бусад байгууллагыг түшиглэн явуулж болно.
- Тойролтын хугацааг тухайн сургалт Хүүхдийн нүүр ам судлал урьдчилан сэргийлэлтийн тасаг, Нүүр амны мэс заслын тасаг, Нүүр амны эмчилгээний тасаг, Хүүхдийн эрүү нүүрний мэс заслын тасаг, нүүр амны гажиг заслын тасаг, амбулатор, тасгийн үзлэгийн болон хагалгааны хэсэг, анги танхим, хурлын заал, номын сангийн хүчин чадалд тохируулан зохицуулна.
- Суралцагч эмчийн өдөр тутмын болон 7 хоногийн үйл ажиллагааны хуваарийг сургалт эрхлэх алба, тасаг боловсруулна.
- Суралцагч нь сургалт эрхлэх байгууллага дээр зохион байгуулагдаж буй Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцаа, хандлага, Халдварын сэргийлэлт, хяналт, Амилуулах суурь тусламж, Эрүүл мэндийн салбарт мөрдөгдөж буй хууль, журам, зөрчлийн тухай хууль, хувь хүний нууц, хүний эрх, хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрх, жендерийн тэгш байдалтай холбоотой хууль, журам, Эмнэлгийн эрх зүй, хөдөлмөрийн аюулгүй байдал, цацрагийн хамгаалалт, радиологи оношилгооны аюулгүй байдлын чиглэлээр сургалтанд (orientation) заавал хамрагдана.

6.2. Зайлшгүй таньж мэдэх, суралцах шаардлагатай шинж тэмдэг, өвчин, гардан үйлдэл:

Сургалтын төгсгөлд ажлын байранд ганцаараа бие даан тусламж үйлчилгээ үзүүлж чадах төвшинд хүрэхийн тулд эмнэлзүйн сургагч багшийн хяналтан дор амбулаториор үйлчлүүлэгч хүүхэд, хэвтэн эмчлүүлж буй өвчтний оношилгоо, эмчилгээг хариуцан хийх явцдаа дараах шинж тэмдэг, өвчин, гардан үйлдлийг гүйцэтгэж туршлага хуримтлуулсан байна.

6.2.1. Өвчний шинж тэмдэг (*sign and symptoms*) (аль ч тойролтод тохиолдох):

1. Хүүхдийн шүд өвдөх
2. Хүүхдийн шүдний өнгө өөрчлөгдөх
3. Хүүхдийн шүд хөдөлгөөнд орох
4. Хүүхдийн шүд гэмтэх
5. Хүүхдийн буйл хавдах
6. Хүүхдийн буйлнаас цус гарах
7. Хүүхдийн буйлнаас идээ гарах
8. Хүүхдийн амны зөөлөн эд гэмтэх
9. Амны салст үрэвсэх
10. Хүүхдийн нүүр хавдах
11. Хүүхдийн нүүр рүү дамжиж өвдөх
12. Халуурах
13. Толгой өвдөх
14. Хоолонд дургүй байх
15. Уйлах, уурлах, дургүйцэх
16. Хүүхдийн амнаас эвгүй үнэр гарах
17. Хүүхдийн ам ангайлт хязгаарлагдах
18. Хүүхдийн өсөлт, хөгжилт хоцрох
19. Шүдлэлтийн хугацаа алдагдах

20. Шүдний байрлал, эгнээ, зуулт алдагдах

6.2.2. Зайлшгүй суралцаж, таньж мэдэх шаардлагатай өвчин эмгэгүүд:

1. Хүүхдийн шүд цоорох өвчин (Dental caries)-K02
2. Хүүхдийн шүдний зөөлцийн өвчин (Pulpitis)-K04
3. Хүүхдийн шүдний сурвалжийн оройн холбоосын өвчин (Apical periodontitis)-K04.4-K04.5
4. Хүүхдийн буйлны үрэвсэл (Gingivitis, plaque induced)-K05.10
5. Хүүхдийн шүдний тулгуур эдийн өвчин-(Periodontal disease)-K05.6
6. Хүүхдийн шүдний цоорлын бус гаралтай хатуу эдийн эмгэг (Disorder of hard tissues of teeth)-K03.9
7. Хүүхдийн амны салстын өвчин (Lesions of oral mucosa)-K13.70
8. Хүүхдийн шүдний гаралтай үрэвсэлт өвчин
9. Хүүхдийн шүдний гэмтэл (Fracture of tooth-Traumatic)-S02.5
10. Хүүхдийн шүдний өсөлт хөгжилтийн гажиг (Anomaly of tooth)-M26.30
11. Хүүхдийн шүдний эгнээ ба зуултын өсөлт хөгжлийн гажиг (Anomaly of dental arch relationship)-M26.20

6.2.3. Гардан үйлдлийн жагсаалт: (Гараар хийж гүйцэтгэх үйлдэл байна)

1. Хүүхдийн шүд амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэг хийх-Oral examination-260
2. Хүүхдийн амны гаднах үзлэг хийх
3. Хүүхдийн амны дотрох үзлэг хийх
4. Хүүхдийн амны зөөлөн эдийн гажиг илрүүлэх үзлэг хийх-Examination of oral soft tissue
5. Шүдний өнгөр тодорхойлох-Determine dental plaque
6. Шүдний өнгөр цэвэрлэх-Cleaning dental plaque
7. Шүдний чулуу цэвэрлэх-Scaling
8. Фторын бэлдмэл хэрэглэх-Flouride application
9. Ховил битүүлэгч тавих-Dental sealant
10. Цоорлыг илрүүлэх уусмал хэрэглэх-Caries indicator
11. Зөөлцийн цахилгаан мэдрэг чанар тодорхойлох-Pulp test
12. Халуун хүйтний сорил хийх-Temperature test
13. Сувгийн урт хэмжих багажаар сувгийн уртыг тодорхойлох-Root canal meter
14. Цоорлыг зогсоох түрхлэг түрхэх-Saforide
15. Сүүн шүдний цоорлын хөндийг хэлбэржүүлэх-Preparation deciduous tooth
16. Бүрэн хэлбэржээгүй байнгын шүдний цоорлын хөндийг хэлбэржүүлэх-Preparation premature permanent tooth
17. Эмчилгээний жийргэвч тавих-capping
18. Тусгаарлах жийргэвч тавих-lining
19. Гласс-иономер цементэн ломбо тавих-Restoration of tooth by glassionomer cement filling-232
20. Хуванцар ломбо тавих-Restoration of tooth by composite filling-232
21. Хуванцар матриц хэрэглэх-transparent matrix
22. Металл матриц, матриц баригч хэрэглэх-metal matrix, matrix retainer

23. Металл түр бүрээсээр цөгцийг сэргээх-Application of crown-2341
24. Шүдний зөөлц сугалах-pulpotomy
25. Шүдний зөөлцийг тайрах-pulpotomy
26. Сүүн шүдний сувар өргөсрөх-root canal preparation of deciduous teeth
27. Бүрэн хэлбэржээгүй байнгын шүдний сувар өргөсрөх- root canal preparation of premature permanent teeth
28. Хүүхдийн шүдний сувар угаах-Root canal therapy with irrigation-2371
29. Хүүхдийн шүдний сувагт эм үлдээх-Root canal therapy with medicine
30. Хүүхдийн шүдэнд түр ломбо тавих- Restoration of tooth by temporary filling
31. Хүүхдийн шүдний түр ломбо авах-Remove temporary filling from tooth
32. Үхжүүлэх бэлдмэл шүдэнд тавих-
33. Амны салстын өвчний үед салстад хэсгийн эмчилгээ хийх-local therapy of oral mucosa
34. Өнгөц мэдээгүйжүүлэлт хийх-local anesthesia
35. Нэвчүүлэх мэдээгүйжүүлэлт хийх-local anesthesia
36. Дамжуулах мэдээгүйжүүлэлт хийх-local anesthesia
37. Гар угааж, халдваргүйжүүлэх-Scrubbing
38. Хагалгааны талбай халдваргүйжүүлэх, тусгаарлах
39. Цэвэр боолт хийх-Bandage clean wound
40. Бохир боолт хийх- Bandage a festering wound
41. Өвчний түүх нээх, хөтлөх-Keep medical record
42. Шинжилгээний хариу уншиж үнэлэх-Assess test results
43. Хүүхдийн шүд авах-Extraction of deciduous tooth-2301
44. Амны хөндийн эрүүл мэндийн боловсрол олгох сургалт явуулах-Improve of oral health education
45. Сургалтын тоног төхөөрөмж ашиглах-Use of technical equipment of lecture
46. Сургалтын илтгэл бэлтгэх-preparation of presentation
47. Шүд угаах арга заах-teaching tooth brushing
48. Хүүхдэд шүд болон шүдний эгнээний гажиг үүсгэдэг эрсдэлт хүчин зүйлийг илрүүлэх үзлэг хийх=Examination for risk factors of dental anomaly
49. Шүд, шүдний эгнээний гажигийн эмчилгээний авагддаг зэмсгийг арчлах-Care removable orthodontic instrument
50. Хүүхдэд булчингийн дасгал заах-Myogymnastics
51. Гажигийг оношлох эмнэл зүйн сорилыг гүйцэтгэх-Clinical test for diagnostic of dental anomaly
52. Зай хадгалах зэмсэг хийж тааруулах-Space maintenance
53. Хүүхдэд амны гаднах рентген зураг авах-Maxillofacial radiography
54. Хүүхдийн амны дотрох рентген зураг авах-Oral radiography

6.3. Онолын мэдлэгийг сайжруулах

Хэлэлцүүлэг-Journal Review (1 сард 2-оос доошгүй өгүүлэл)

- Резидент эмч нь удирдагч багштай хамтран сургалтын болон шинжлэх ухааны өгүүллийг сонгон авч уншиж бэлтгэнэ
- Резидент эмч нь өөрийн сонгож авсан өгүүллийг багш ба бусад резидент эмч нарт 15 минутын хугацаанд танилцуулан тайлбарлаж, хэлэлцүүлнэ

- Өгүүлэл нь сүүлийн 10 жилийн хугацаанд хэвлэгдсэн байхыг шаардана.

Номын хэлэлцүүлэг-Book Review (1 сард 1 удаа нэгдүгээр дамжааны резидент эмч)

- Хүүхдийн Нүүр Ам Судлал, Pediatric Dentistry Textbook, Детская стоматология номын өөрт оногдсон бүлгийг резидент эмч хэлэлцүүлэгт бэлдэж ирнэ.
- Хэлэлцүүлэгт 20-30 минутад багтаан өөрт оногдсон бүлгийг багш ба бусад резидент эмч нарт 15 минутын хугацаанд танилцуулан тайлбарлаж, хэлэлцүүлнэ

Тохиолдлын хэлэлцүүлэг-Case discussion (1 сард 2-оос доошгүй удаа)

- Резидент эмч нь сургалтын эмнэлэгт өөрийн эмчилсэн, ажигласан, хагалгаа мэс ажилбарт нь оролцсон өвчтөний амбулатори болон тасагт байсан бүхэл бүтэн түүхийг бэлтгэнэ.
- Чухал бөгөөд зонхилон тохиолддог өвчний түүхийг шаардана
- Бүтэн түүхийг багтаана: Гол зовиур, өвчний түүх, бодит үзлэг, нэмэлт шинжилгээ, урьдчилсан оношийн таамаг, эмчилгээ, эмчилгээний үр дүн, тавиланг танилцуулах ба тухайн өвчний талаарх онолын мэдээллийг хүргэнэ.
- Бэлтгэсэн түүхийг 15 минутад багтаан бусад резидент эмч нарт танилцуулна.
- Хэлэлцүүлэг профессорын багийн ахлах болон Профессор багшийн удирдлагад явагдана.

Хүүхдийн нүүр ам судлаач эмч нарын чуулганд (1 жилд 1 удаа)

- Хоёрдугаар дамжааны резидент эмч нь чуулганд судалгааны үр дүн болон эмнэлзүйн тохиолдол бэлтгэнэ
- Чуулганы удирдамжийн дагуу илтгэлийг бэлтгэж хэлэлцүүлнэ
- Сургалт эрхлэх байгууллагын эмнэлзүйн сургалт удирдах эрхтэй багш болон профессор багшийн удирдлага дор хэлэлцүүлэгт оролцоно.
- Нэгдүгээр дамжааны резидент эмч чуулганы зохион байгуулалтын үйл ажиллагаанд зохицуулагч багшийн гаргасан хуваарийн дагуу заавал оролцоно.

Бусад хэлэлцүүлэг

- Нэг ба хоёрдугаар дамжааны резидент эмч нар Хүүхдийн нүүр ам судлал, урьдчилан сэргийлэлтийн тэнхим болон координатор багшийн удирдлага зөвшөөрлийн дагуу нэр хүндтэй профессор багш нар болон зөвлөх эмч нарын сургалт лекцэнд оролцоно.

Загвар 1

Ажлын байрны сургалт (On-the-Job Training)

№	Сургалтын хэлбэр	Резидент эмчийн тоо	Үргэлжлэх хугацаа давтамж	Сургалт явагдах газар	Хэрэглэг дэхүүн	Удирдагч, хамтрагч
1	Хүүхдийн шүд амны үзлэг	5	8 цаг, 7 хоногт 3 удаа	Хүүхдийн шүдний	өвчтөн	Эмнэлзүйн сургагч багш, эмч

2	Хяналтын тойрон үзлэг	2	4 цаг, 7 хоногт 1 удаа	эмчилгээний тасаг	өвчтөн	Эмнэлзүйн сургагч багш, эмч
3	Сургалтын тойрон үзлэг	2	1 цаг, 7 хоногт 4 удаа		өвчтөн	Эмнэлзүйн сургагч багш, эмч
4	Гардан хийх үйлдэл	5	4 цаг, 7 хоногт 1 удаа		өвчтөн	Эмнэлзүйн сургагч багш, эмч
5	Мэс ажилбарт оролцох	2	1 цаг, 7 хоногт 1 удаа	Мэс заслын тасаг	өвчтөн	Эмнэлзүйн сургагч багш, эмч

Хяналтын тойрон үзлэг: Суралцагч эмч хүүхдийн шүдний эмчилгээний тасагт үйлчлүүлэхээр ирж байгаа хүүхдийн зовиур болон хийгдэх нэмэлт шинжилгээний талаар эмнэлзүйн сургагч багш болон бусад эмчид танилцуулах зорилготой. Үүний тулд хүүхдийн нүүр ам судлал урьдчилан сэргийлэлтийн тасагт анх удаа үйлчлүүлэхээр ирсэн хүүхдийг угтан авч, бие даан асуумж цуглуулан, өвчний түүхтэй танилцан, хүүхдийн биеийн байдлыг үнэлж, урьдчилсан оношийг дэвшүүлэн эмнэлзүйн сургагч багш болон эмчид танилцуулахад бэлдэнэ. Танилцуулгыг сургалтын өрөө зэрэг эмнэлзүйн бус өрөөнд хийнэ. Хяналтын тойрон үзлэгээр өвчтөнөөс асуумж авах, үзлэг хийх аргад суралцана.

Сургалтын тойрон үзлэг: Сургалтад тохиромжтой нэг өвчтөн сонгож, мэргэжлийн үзлэг шинжилгээ хийж, урьдчилсан онош тавьж, эмчилгээний төлөвлөгөө боловсруулан эмнэлзүйн сургагч багш болон хамтран суралцагч нарт танилцуулж хэлэлцүүлэг өрнүүлэн байж болох хувилбарыг харилцан ярилцана.

Загвар 2

Танхимын сургалт (On-the-Job Training)

№	Аргачлал	Резидент эмчийн тоо	Үргэлжлэх хугацаа давтамж	Сургалт явагдах газар	Хэрэглэг дэхүүн	Хамтрагч
1	Бие даалт	1	4 цаг, 7 хоногт 1 удаа	Номын сан, сургалтын танхим	Ном сурах бичиг, интернет	Суралцагч, хамтран суралцагч
2	Лекц	44 доошгүй	14 хоногт 1 удаа	Сургалтын танхим	РРТ	Зөвлөх эмч, профессор багш
3	Хэлэлцүүлэг	44 доошгүй	1 цаг, 7 хоногт 1 удаа	Сургалтын танхим	Ном, сэтгүүл, өгүүлэл	Эмнэлзүйн сургагч багш
4	Семинар	44 доошгүй	1 цаг, 7 хоногт 1 удаа	Сургалтын танхим	Хэвлэлийн тойм	Эмнэлзүйн сургагч багш

Үйл ажиллагааны хуваарь

Цаг	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан
08:30-12:30	Амбулаторийн үзлэг	Амбулаторийн үзлэг	Хяналтын тойрон үзлэг	Амбулаторийн үзлэг	Сургалтын тойрон үзлэг
12.30-13.30	Семинар	Лекц	Мэс ажилбарт орох	Семинар	Хэлэлцүүлэг
13:30-17:30	Амбулаторийн үзлэг	Амбулаторийн үзлэг	Гардан үйлдэл	Амбулаторийн үзлэг	Бие даалт

Тойролтын хуваарь

Эмнэлзүйн тойролтууд	Хугацаа	Тойролт хийх эмнэлгүүд
Хүүхдийн нүүр амны мэс заслаар судлах ерөнхий зүйлс	2 долоо хоног	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн эрүү нүүрний мэс заслын тасаг
Хүүхдийн шүд эрүү нүүрний үрэвсэлт өвчин	2 долоо хоног	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн эрүү нүүрний мэс заслын тасаг
Хүүхдийн амны хөндийн эрүүл мэндийг хянах, эрүүл мэндийн боловсрол- нийгмийн эрүүл мэнд	10 долоо хоног	гийн Хүүхдийн нүүр ам судлал урьдчилан сэргийлэлтийн тасаг
Хүүхдийн нүүр амны гажиг засал, урьдчилан сэргийлэлтийн асуудал	2 долоо хоног	Нүүр амны гажиг заслын тасаг
Хүүхдийн нүүр ам судлал	12 долоо хоног	Хүүхдийн нүүр ам судлал урьдчилан сэргийлэлтийн тасаг
Хүүхдийн шүд эрүү нүүрний эрхтнүүдийн рентген оношилгоо	2 долоо хоног	Нүүр амны дүрс оношилгооны тасаг
Хүүхдийн нүүр амны өвчний урьдчилан сэргийлэлт	14 долоо хоног	Хүүхдийн нүүр ам судлал урьдчилан сэргийлэлтийн тасаг
Хүүхдийн нүүр амны өвчний эмчилгээ	21 долоо хоног	Хүүхдийн нүүр ам судлал урьдчилан сэргийлэлтийн тасаг
Хүүхдийн салстын өвчний оношилгоо, эмчилгээний зарчим	2 долоо хоног	Нүүр амны эмчилгээний тасаг
Хүүхдийн нүүр амны өвчний эмчилгээ	21 долоо хоног	Хүүхдийн нүүр ам судлал урьдчилан сэргийлэлтийн тасаг

НИЙТ	88 долоо хоног	
------	-------------------	--

6.4. Тойролтын агуулга

Хүүхдийн нүүр амны мэс заслаар судлах ерөнхий зүйлс (тойролт-1)

- Хүүхдийн нүүр амны мэс заслын хөгжлийн түүх, орчин үеийн шаардлага, хэтийн төлөв
- Хүүхдийн нүүр амны мэс заслын тасгийн зохион байгуулалт, ажиллах зарчим, хагалгаа болон боолтын өрөөнд баримталж мөрдөх дэг журам
- Халдвар хамгаалал, асептик, антисептикийн онолын үндэс
- Гар халдваргүйжүүлэх, хагалгааны талбай халдваргүйжүүлэх, тусгаарлах арга
- Шүдний гаралтай үрэвсэлт өвчний эмнэлзүй, оношилгоо, эмчилгээний ерөнхий зарчим
- Шарх, түүний үе шат, эмчилгээний үндсэн зарчим
- Цэвэр болон идээт шарх угааж цэвэрлэх, боолт хийх
- Амбулаторид хийгдэх хүүхдийн шүд эрүү нүүрний жижиг мэс ажилбарууд, (хүүхдийн сүүн болон бүрэн хэлбэржээгүй байнгын шүд авах, шүдлэлтийн уйланхай, шүдний гаралтай буглаа, амны зөөлөн эдийн гаж хөгжил)
- Хүүхдийн нүүр амны эмчилгээ, жижиг мэс ажилбарын үед цус алдах, цус тогтоох арга
- Үйлчлүүлэгчийг шинжлэх үндсэн ба туслах аргууд
- Лабораторийн шинжилгээ төлөвлөх, шинжилгээний хариу унших, үнэлэх, оношилгоонд ашиглах
- Хэсгийн нэвчүүлэх, өнгөц, дамжуулах мэдээгүйжүүлэлт хийх, өвдөлт айдасгүй ажиллах
- Хүүхдийн сэтгэл санааг тайвшруулах
- Хүүхдийн сүүн болон бүрэн хэлбэржээгүй байнгын шүд авах
- Шүдлэлтийн уйланхай нээх
- Шүдний гаралтай буглаа нээх
- Хэл ба уруулын хөвчийг уртасгах
- Эмийн эмчилгээ төлөвлөх, явуулах, эмийн жорыг хүүхдийн нас биеийн онцлогт тохируулан бичих
- Хүүхдийн эцэг эх асран хамгаалагчид энгийн ойлгомжтой үг хэллэгээр зөвлөгөө өгөх

Хүүхдийн шүд эрүү нүүрний үрэвсэлт өвчний оношилгоо, анхны тусламж (тойролт-2)

- Хүүхдийн эрүү нүүрний орчмын ясны хальсны үрэвсэл, эмгэг жам, эмнэл зүй, ангилал, оношилгоо, ялгах онош, эмчилгээ
- Хүүхдийн эрүү нүүрний орчмын тунгалагийн булчирхайн үрэвсэл, эмгэг жам, эмнэл зүй, ангилал, оношилгоо, ялгах онош, эмчилгээ

- Хүүхдийн эрүү нүүрний орчмын ясны идээт үхжилт үрэвсэл, эмгэг жам, эмнэл зүй, ангилал, оношилгоо, ялгах онош, эмчилгээ
- Хүүхдийн эрүү нүүрний орчмын буглаа, эмгэг жам, эмнэл зүй, ангилал, оношилгоо, ялгах онош, эмчилгээ
- Хүүхдийн эрүү нүүрний орчмын нэвчээс, эмгэг жам, эмнэл зүй, ангилал, оношилгоо, ялгах онош, эмчилгээ
- Хүүхдийн эрүү нүүрний орчмын үрэвсэлт өвчний үеийн ажиглалт, шинжилгээ, оношилгооны зарчим
- Хүүхдийн эрүү нүүрний орчмын үрэвсэлт өвчний үед рентген зурагт гарах өөрчлөлтүүд, илрэх онцлог шинж тэмдгүүд
- Хүүхдийн эрүү нүүрний орчмын үрэвсэлт өвчний үед лабораторийн шинжилгээнд гарах эмгэг өөрчлөлтүүд
- Хүүхдийн эрүү нүүрний орчмын үрэвсэлт өвчний эмийн болон мэс заслын эмчилгээний зарчим
- Эмчилгээний үеийн болон дараах хооллолт
- Өвчтөн шилжүүлэх, чиглүүлэх шаардлагатай тохиолдлууд

Хүүхдийн амны хөндийн эрүүл мэндийг хянах, эрүүл мэндийн боловсрол-нийгмийн эрүүл мэнд (тойролт-3)

- Хүүхдийн хооллох үйл ажиллагааны хөгжилтийг дэмжихэд нүүр амны эмчийн үүрэг
- Бор хоолны үеийн хооллох үйл ажиллагааны өсөлт хөгжилтийн үе шат
- Балчир үеийн хооллох үйл ажиллагааны өсөлт хөгжилт, хоолны хэлбэр
- Сургуулийн өмнөх насны үеийн хооллох үйл ажиллагааны өсөлт хөгжилт, хоолны хэлбэр
- Сургуулийн үеийн хооллох үйл ажиллагааны өсөлт хөгжилт, хоолны хэлбэр
- Хүүхэд үеийн амны хөндий-нийгмийн эрүүл мэндийн тухай ойлголт, амны хөндийн эрүүл мэндийг дээшлүүлэх тухай
- Амны хөндийн эрүүл мэндийг дэмжих (Health promotion) тухай
- Сургуулийн нүүр амны эмчийн үүрэг, үйл ажиллагаа болон сургуулийн нүүр амны эрүүл мэндийн оношилгооны агуулга
- Сургуулийн өмнөх нас, цэцэрлэг, сургуулийн насны хүүхдийн нүүр амны эрүүл ахуй

Хүүхдийн нүүр амны гажиг засал, урьдчилан сэргийлэлтийн асуудал (тойролт-4)

- Хүүхдийн шүдний эгнээ ба зуултын хэвийн өсөлт-хөгжилт
- Хүүхдийн шүд шүдлэлтийн байдал
- Хоршилтыг залах, зай хадгалах
- Шүдний эгнээ, зуултыг үнэлэх
- Зуултыг залах механик аргын үед хэрэглэх үндсэн зэмсгүүд
- Рентген зургаар шинжлэх ба анализ хийх
- Шүд шүдлэлтийн эмгэг
- Зуултын гажиг
- Амны буруу зуршлын төрөл, нөлөө

- Хүүхдийн гажиг заслын эмчилгээний үед багаар ажиллах

Хүүхдийн нүүр ам судлал (тойролт-5)

- Хүүхдийн эмчилгээ ба өсөлт хөгжилтийн эмчилгээний ялгаа
- Хүүхэд үеийн нүүр амны эрүүл мэндийн үйлчилгээний ач холбогдол, онцлог
- Хүүхдийн амны хөндийн менежментийн өвөрмөц онцлог, агуулга
- Нүүр амны эмчийн үүрэг, хариуцлага
- Хүүхдийн бие махбодын өсөлт, өсөлт-хөгжилтийн процессын онцлог
- Хүүхдийн оюун ухаан, сэтгэхүй, хөдөлгөөний эрхтний хөгжилт
- Сэтгэл хөдлөлийн ангилал, айдас
- Амны хөндий, гавал, эрүү нүүр орчмын эрхтнүүдийн хөгжилт, өсөлт, өсөлт-хөгжилт
- Амны хөндийн эрхтнүүдийн үйл ажиллагааны хөгжилт
- Сүүн, байнгын шүдний онцлог

Хүүхдийн шүд, эрүү нүүрний эрхтнүүдийн рентген оношилгоо (тойролт-6)

- Рентген цацрагийн үндсэн ойлголт
- Рентген цацрагийн физик, химийн шинж чанар, ионжуулагч үйлчилгээ, хамгаалалтын хэрэгслүүд, хэмжих багажууд, дозиметр
- Рентген тасаг кабинетын зохион байгуулалт, ажиллах журам
- Рентген шинжилгээний үндсэн ба туслах аргууд, давуу ба дутагдалтай талууд
- Дэлгэмэл рентген зургийн оношилгоо
- Дэлгэмэл рентген зураг авах арга, анхаарах зүйлс
- Дэлгэмэл рентген зурагт харагдах анатомийн бүтэцүүд
- Дэлгэмэл рентген зураг авах үед үүсч болох алдаанууд
- Хүүхдийн практикт дэлгэмэл рентген зурагт гарч болох эмгэг өөрчлөлтүүд
- Эрүүний дэлгэмэл рентген зураг
- Хоншоорын дэлгэмэл рентген зураг
- Үений дэлгэмэл рентген зураг
- Дайвар хөндийн дэлгэмэл рентген зураг
- Хажуугийн телерентген зураг
- Эгц урдаас телерентген зураг
- Гавлын хажуугийн болон эгц өөдөөс зураг авах үед гарч болох алдаанууд
- СВСТ-ын тухай ерөнхий ойлголт, ажиллах зарчим
- Аман доторх зураг авах арга
- Аман доторх зураг авах аргын төрлүүд
- Шүдний сурвалжийн оройн рентген зураг авах арга, анхаарах зүйлс
- Шүдний сурвалжийн оройн рентген зурагт харагдах анатомийн бүтэцүүд
- Хоршилтын рентген зураг авах арга, анхаарах зүйлс
- Хазалтын рентген зураг авах арга, анхаарах зүйлс

Хүүхдийн нүүр амны өвчний урьдчилан сэргийлэлт (тойролт-7)

- Кеуес нарын шүд цоорох өвчнийг үүсгэгч 3 хүчин зүйлс ба шүд цоорох өвчин үүсэх механизм
- Мутанс стрептококк (*Streptococcus mutans*) нянгийн эхээс хүүхдэд дамжих механизм
- Шүд цоорох өвчин ба хооллолтын хамаарал
- Балчир ба сургуулийн өмнөх насны хүүхдэд тохирсон шүд угаах арга
- Цоорлыг хянах
- Шүдний тулгуур эдийн өвчний урьдчилан сэргийлэлт

Хүүхдийн нүүр амны эмчилгээ (тойролт-8)

- Сүүн шүд болон бүрэн хэлбэржээгүй байнгын шүдний шүд цоорох өвчний тархвар зүйн зорилго, чиглэл
- Хүүхдэд үүсэх шүдний тулгуур эдийн өвчин, бие махбодын өвчин ба шүдний тулгуур эдийн өвчний хамаарал
- Хүүхдийн бие махбод, мэдрэл болон сэтгэл санааны онцлог ба нүүр амны эмчилгээний үед анхаарах зүйлс
- Нүүр амны эмчилгээний өрөөнд үйлчлүүлэгч хүүхэдтэй тааламжтай харилцах чадварыг эзэмших, хүүхдэд тохирсон өвөрмөц харилцааны аргыг ойлгох ба суралцах
- Хүүхдийн шинжилгээ, ажиглалт, оношилгоо, амны хөндийн эмнэл зүйн менежмент
- Цөгцийг ломбодох буюу сэргээх арга
- Сүүн шүд болон бүрэн хэлбэржээгүй байнгын шүдэнд тохирсон шүдний сурвалжийн сувгийн эмчилгээний үндсэн агуулга
- Оюун санааны болон бие махбодын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нүүр амны эмчилгээ
- Бие махбодын өвчтэй хүүхдэд хийгдэх нүүр амны эмчилгээний үед анхаарах зүйлс

Амны салстын өвчин (тойролт-9)

- Амны салстын өвчнүүдийн шалтгаан
- Эмгэг жам
- Ангилал
- Эмгэг эд судлал
- Эмнэл зүй
- Ялгах онош
- Оношилгоо
- Эмчилгээ
- Урьдчилан сэргийлэх арга зам
- Салст дээр гарсан морфологи элементүүдийг ялгаж таних
- Эмээр шавшлага хийх

- Салстын эмгэгийн үеийн цусны ерөнхий шинжилгээг уншиж үнэлгээ дүгнэлт өгөх
- Дархлааны эсийн дэлгэрэнгүй шинжилгээг уншиж дүгнэлт өгөх
- Менежментийн ур чадвар
- Гэр бүл, асран хамгаалагчтай харилцах чадвар
- Эрүүл мэндийн сурталчилгаа

ДОЛОО. ҮНЭЛГЭЭ, ЭРГЭН ЗӨВЛӨГӨӨ

- 7.1. Сургалт эрхлэх байгууллага нь ажлын байрны сургалтыг удирдан явуулах эмнэлзүйн сургагч багш нарыг томилон хуваарилна. Сургалтын явц, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, суралцагч эмчийн хувийн төлөвлөгөөний (career plan) талаар зөвлөлдөх, хяналт тавих сургалт хариуцагч (mentor)-ыг сургалт эрхлэх байгууллага томилон ажиллуулна. Сургалт хариуцагч нь сар бүр нэг удаа тогтмол уулзалт зохион байгуулж суралцагч эмч нартай мэдээлэл солилцож үнэлгээтэй танилцана.
- 7.2. Тойролт бүрт суралцагч эмчийг сүлжээнд нэгдсэн эмнэлгүүдэд илгээж тойролтын хугацаанд хэрэгжүүлэх зорилтуудыг танилцуулна. Тойролт дуусахад тойролт удирдсан багштай ярилцлага хийж, сургалтын үнэлгээ, зөвлөгөө авна
- 7.3. Үнэлгээний арга нь сургалтын явцын үнэлгээ, төгсөлтийн шалгалт гэсэн хоёр хэлбэрээр хийгдэнэ.
 - Хүүхдийн нүүр ам судлалын мэргэшигч эмч сургалтын төгсөлтийн шалгалт өгнө. Шалгалтад тэнцсэн тохиолдолд Хүүхдийн нүүр ам судлалын үндсэн мэргэшлийн диплом олгоно.
 - Явцын буюу ажлын байранд суурилсан үнэлгээ нь дараах аргуудаар явагдана. Явцын үнэлгээ нь нийт үнэлгээний 80-аас доошгүй хувийг эзэлнэ.

Ажлын байранд суурилсан үнэлгээ

Workplace-based assessment-360 хэмийн үнэлгээ (360 Degree assessment):

Суралцагч эмчийн мэргэжлийн (professional) байх, манлайлагч (leader) байх чадамжийг үнэлэхэд ашиглана. Үнэлгээ хийх хүнийг сургалтын албанаас томилно. Үнэлгээний дүнг суралцагч эмч болон хариуцагчид танилцуулж, үнэлгээнд үндэслэсэн эргэн зөвөлгөөг хариуцагчаас суралцагчид өгнө. Хяналтын дэвтрээс ирцийн үнэлгээг сургалтын алба гаргаж нэгтгэнэ.

Mini-CEX Эмнэлзүйн дасгал үнэлгээ (Mini-Clinical Evaluation Exercise):

Ажлын байрны сургалтын хөтөлбөрт заагдсан заавал таньж мэдэх 20 шинж тэмдгүүдээс 5-аас доошгүй үйлдэл бүрд 3-аас доошгүй удаа нийт 15-аас цөөнгүй удаа үнэлгээ хийнэ.

Ур чадварыг шууд ажиглан дүгнэх үнэлгээ (Direct observation of procedural skills. DOPS):

Сургалтын эхний жилд ажлын байрны сургалтын хөтөлбөрт заагдсан заавал хийж гүйцэтгэх 54 үйлдлээс 45-аас доошгүй үйлдлийг хийж чаддаг болсныг эмнэлзүйн

удирдагч багш нотолсон үнэлгээ. Үнэлгээний дүнг суралцагч эмч болон хариуцагчид танилцуулж, үнэлгээнд үндэслэн эргэн зөвөлгөөг хариуцагчаас суралцагчид өгнө.

Портфолио үнэлгээ (Portfolio Assessment):

Суралцагч эмч нь сургалтын хугацаанд оролцсон сургалт, эрүүл мэндийн сурталчилгаа хийсэн материал зэрэг сургалттай холбоотой бичиг баримтыг цуглуулж өөрийн сургалтын хавтсанд хадгална.

7.4. Үнэлгээний дүнг хянах. Суралцагч эмч нь тойролт бүрийн төгсгөлд эмнэлзүйн сургагч багшийн өгсөн үнэлгээг сургалтын албанд хүлээлгэн өгч тэмдэглүүлнэ. Сургалтын алба үнэлгээний дүнг сургалтын хяналтын зөвлөлд нэгтгэн танилцуулж байна.

7.5. Сургалтын төгсөлтийг шийдвэрлэх. Сургалтын хяналтын зөвлөл нь тойролт бүрд хийгдсэн Mini-CEX, DOPS, 360 хэмийн үнэлгээний нэгдсэн дүн, суралцагчийн сургалтын ирц, хөтөлбөрт заагдсан зайлшгүй шинж тэмдэг, өвчний тохиолдол, гардан үйлдлийн тоог харгалзан төгсөлтийн эцсийн шийдвэрийг гаргана. Шийдвэр гаргах шалгуур нь:

- Зайлшгүй сургалтад оролцсон байх өдрийн тоо буюу ирц, сургалтын ирц хангалтгүй бол тасарсан сургалтын өдөр, агуулгыг нөхүүлнэ.
- Зайлшгүй таньж мэдэх 20 шинж тэмдэгээс 1 жилийн хугацаанд 15-аас доошгүйг оношилж, эмчилж туршлага хуримтлуулсан байна.
- “Хүүхдийн нүүр ам судлал” үндсэн мэргэшлийн сургалтын тойролт бүрт заагдсан өвчний бүх тохиолдлыг тус бүр 50-иас доошгүй удаа үзэж туршлага хуримтлуулсан байна.
- “Хүүхдийн нүүр амны мэс засал”-ын тойролт дээр заагдсан бүх тохиолдлыг тус бүр 5-аас доошгүй удаа үзэж туршлага хуримтлуулсан байна.
- “Хүүхдийн шүдний гаралтай үрэвсэлт өвчин”-ий тойролт дээр заагдсан бүх тохиолдлыг тус бүр 5-аас доошгүй удаа үзэж туршлага хуримтлуулсан байна.
- “Хүүхдийн амны хөндийн эрүүл мэндийг хянах, эрүүл мэндийн боловсрол-нийгмийн эрүүл мэнд” тойролт 3 дээр заагдсан бүх сургалтыг тус бүр 10-аас доошгүй удаа үзэж туршлага хуримтлуулсан байна.
- “Хүүхдийн нүүр амны гажиг засал”-ын тойролт дээр заагдсан бүх тохиолдлыг тус бүр 5-аас доошгүй удаа үзэж туршлага хуримтлуулсан байна.
- “Хүүхдийн нүүр ам судлал”-ын тойролт дээр заагдсан өвчний бүх тохиолдлыг тус бүр 12-оос доошгүй удаа үзэж туршлага хуримтлуулсан байна.
- “Хүүхдийн шүд эрүү нүүрний эрхтнүүдийн рентген оношилгоо”-ны тойролт дээр заагдсан рентген зургийн төрлийг тус бүр 10-аас доошгүй удаа үзэж туршлага хуримтлуулсан байна.
- “Хүүхдийн нүүр амны өвчний урьдчилан сэргийлэлт”-ийн тойролт дээр заагдсан бүх тохиолдлыг тус бүр 10-аас доошгүй удаа үзэж туршлага хуримтлуулсан байна.
- “Хүүхдийн нүүр амны эмчилгээ” тойролт дээр заагдсан бүх тохиолдлыг тус бүр 20-оос доошгүй удаа үзэж туршлага хуримтлуулсан байна.
- “Хүүхдийн амны салстын өвчин”-ий тойролт дээр заагдсан бүх тохиолдлыг тус бүр 1-ээс доошгүй удаа үзэж туршлага хуримтлуулсан байна.

- Зайлшгүй суралцах 54 гардан үйлдлээс нэг жилийн хугацаанд 80%-иас цөөнгүйг хийж гүйцэтгэн туршлага хуримтлуулсан байна

НАЙМ. ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ, ХЯНАЛТ

8.1. Сургалтын хяналтын зөвлөл

- Сургалт эрхлэх байгууллагын сургалтын албаны дарга, эмнэлгийн тусламж үйлчилгээ эрхэлсэн дэд дарга, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Эрүү нүүрний мэс заслын тасаг, сувилахуйн албаны төлөөлөл, суралцагч эмчийн төлөөллөөс бүрдэнэ.
- Сургалтын хяналтын зөвлөл нь эмнэлгийн тусламж үйлчилгээ эрхэлсэн даргын шууд удирдлага доор ажиллана
- Сургалтын хяналтын зөвлөл нь улиралд нэгээс доошгүй удаа хуралдана.
- Сургалтын хяналтын зөвлөл нь суралцагч эмчийн сургалт, тулгарсан асуудалтай танилцах, суралцагч эмчтэй холбоотой бүх асуудлыг ярилцаж, шийдвэрлэх арга замыг судалдаг бүтэц байна.
- Сургалтын хяналтын зөвлөлийн гишүүд нь сургалтыг илүү сайжруулахын тулд өөрийн мэдлэг, боловсролоо дээшлүүлэхийг зорьж ажиллана.

8.2. Хөтөлбөрийн хяналт

- Сургалтын алба хөтөлбөрт хяналт хийнэ.
- Хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардлагатай сургалтын төлөвлөгөө гаргах, эмнэлзүйн сургагч багшид чиглэсэн сургалт, суралцагч эмчийн нийгмийн асуудалд дэмжлэг үзүүлэх, шаардагдах санхүүжилтийг төсөвт тусгах зэргийг сургалтын алба хариуцна.
- Хөтөлбөрт нэмэлт, өөрчлөлт хийх шаардлагатай тохиолдолд сургалтын хяналтын зөвлөлд оруулж, хэлэлцүүлэн өөрчлөлт хийнэ. Энэ тухай Эрүүл мэндийн хөгжлийн төвд албан бичгээр ажлын 10 хоногт багтаан мэдэгдэнэ.

Хавсралт 1

360 ХЭМИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

..... он.....сар.....

Суралцагч эмчийн нэр.....

Үнэлгээ хийгч: () эмнэлзүйн сургагч багш () сувилагч () бусад

Суралцагч эмчийг ажигласны үндсэн дээр, бусдаас сонссон, мэдсэн зүйл дээр бус суралцагч эмчийн зан үйлийг хэр давтамжтай байсныг өөрийн ажигласнаар оноо тавина уу.

Тухайн асуултад үнэлгээ авах боломжгүй бол 0

Тухайн асуултыг 19% биелүүлсэн бол 1;

20-49% биелүүлсэн бол 2;

50-79% биелүүлсэн бол 3;

80-аас дээш биелүүлсэн бол 4 гэсэн үнэлгээ өгнө.

Өвчтөн гэр бүлийн хувийн асуудлыг хүндэтгэдэг	☐ NA	☐ 1	☐ 2	☐ 3	☐ 4
---	-----------------------------	----------------------------	----------------------------	----------------------------	----------------------------

Эмнэлгийн бичиг баримтыг бүрэн гүйцэд, гаргацтай, цаг хугацаанд нь хөтөлдөг	☐ NA	☐ 1	☐ 2	☐ 3	☐ 4
Нүүр амны мэс заслын эрүүл мэндийн асуудалд өөрийн санаачлагаар хувь нэмрээ оруулдаг	☐ NA	☐ 1	☐ 2	☐ 3	☐ 4
Өвчтөний бие даасан байдлыг хүндэтгэж, өвчтөнд тохирсон хамгийн зөв шийдвэрийг гаргахыг хичээн зүтгэл гаргадаг	☐ NA	☐ 1	☐ 2	☐ 3	☐ 4
Хувь хүний онцлогийг харгалзан өвчтөнийг хүндэтгэн эмчилдэг	☐ NA	☐ 1	☐ 2	☐ 3	☐ 4
Өөрийн эмнэл зүйн ур чадварыг дээшлүүлэхийн тулд сургалт болон бусад боломжийг алдалгүй ашигладаг	☐ NA	☐ 1	☐ 2	☐ 3	☐ 4
Өөрийн анагаах ухааны онолын мэдлэгээ дээшлүүлэхийн тулд бие даан суралцдаг	☐ NA	☐ 1	☐ 2	☐ 3	☐ 4
Өөрийн анагаах ухааны онолын мэдлэгээ дээшлүүлэхийн журнал клуб, эмнэл зүйн хэлэлцүүлэгт идэвхитэй оролцдог	☐ NA	☐ 1	☐ 2	☐ 3	☐ 4
Орон нутгийн болон бусад эмнэлгийн мэргэжил нэгт эмч нартай хамтран ажилладаг, сурсан мэдлэгээ хуваалцдаг	☐ NA	☐ 1	☐ 2	☐ 3	☐ 4
Эмнэлэг доторх бусад эмч, сувилагч, мэргэжилтэнтэй, хамтран ажилладаг	☐ NA	☐ 1	☐ 2	☐ 3	☐ 4
Эмнэлэг доторх тусламж, үйлчилгээнд зохион байгуулах, манлайлах үүрэгтэйгээ ухамсарладаг	☐ NA	☐ 1	☐ 2	☐ 3	☐ 4

1 эсвэл 4 оноо өгсөн бол шалтгаанаа бичнэ үү

1.
2.
3.

Хавсралт 2

ЯВЦЫН MINI-CEX ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

.....он.....сар.....

Суралцагч эмчийн нэр..... Үнэлэгчийн нэр.....

Сургалт эрхлэх байгууллага: нэгж

Өвчтөний нас эр эм

Өвчтөний зовиур: Шинж тэмдэг (signs and symptoms)

1. шүд өвдөх, 2. шүдний өнгө өөрчлөгдөх, 3. шүд хөдөлгөөнд орох, 4. шүд гэмтэх, 5. буйл хавдах, 6. буйлнаас цус гарах, 7. буйлнаас идээ гарах, 8. зөөлөн эд гэмтэх, 9. амны салст үрэвсэх, 10. нүүр хавдах, 11. нүүр рүү дамжиж өвдөх, 12. Халуурах, 13. толгой өвдөх, 14. хоолонд дургүй байх, 15. уйлах, уурлах, дургүйцэх, 16. амнаас эвгүй үнэр гарах, 17. ам ангайлт хязгаарлагдах, 18. өсөлт, хөгжилт хоцрох, 19. шүдлэлтийн хугацаа алдагдах, 20. Шүдний байрлал, эгнээ, зуулт алдагдах

Сургалтын явцад суралцагч эмч ямар түвшинд байгааг өөрийн ажигласнаар үнэлнэ үү				
№	Үнэлгээ	Хангалтгүй	Завсрын	Хангалттай
1	Өвчний өгүүлэмж авах			
2	Бодит үзлэг			
3	Оношилгоо, эмчилгээний менежмент			
4	Харилцааны ур чадвар			
5	Эмнэл зүйн ерөнхий чадвар			
Сайн талууд		Сайжруулахад чиглэсэн зөвлөгөө		Бусад санад

Сайжруулахын тулд зөвшилцөж биелүүлэх үйлдэл

Үнэлэгчийн гарын үсэг..... Суралцагчийн гарын үсэг.....

“Хангалттай” гэж тодорхойлоход хэрэглэгдэх үзүүлэлтүүд

Өвчний өгүүлэмж авах	• Ялган оношилгоо хийхүйц дэлгэрэнгүй асуумж авдаг. • Өвчтөний хэрэгцээг илрүүлж хариу үзүүлдэг Өвчтөний дохио зангааг ойлгож тохиромжтой хариу үзүүлдэг
Бодит үзлэг	• Ялган оношилгоо хийхүйц дэс дараалсан бодит үзлэг хийдэг. Үзлэгийн үед өвчтөнд таатай байдал бүрдүүлэхэд анхаардаг
Оношилгоо эмчилгээний менежмент	• Зөв онош тавьдаг. • Оношилгоо, эмчилгээнд шаардлагатай шинжилгээ төлөвлөж, үр дүнг ашигладаг • Тохирсон эмчилгээ эхлүүлдэг. Бусад нарийн мэргэжлийн эмч нартай хамтарч үзлэг эмчилгээг хэлэлцэж, шаардлагатай бол тохирсон тасаг, эмнэлэгт шилжүүлж, хяналт тавьдаг.
Харилцааны ур чадвар	• Өвчтөн, түүний гэр бүл, асран хамгаалагч, төрөл, садны хүнийг сайн сонсдог. • Өвчтөн, түүний гэр бүл, асран хамгаалагч, төрөл, садны хүний зовнилыг хуваалцаж, хүндэтгэлтэй ханддаг. Өвчтөн, түүний гэр бүл, асран хамгаалагч, төрөл, садны хүнтэй эелдэг, энгийн үг хэллэг хэрэглэж харилцдаг.

Эмнэлзүйн ур
чадвар

- Системтэй (харилцан уялдаатай) арга замыг тодорхойлдог.

Хавсралт 3

ГАРДАН ҮЙЛДЛИЙН УР ЧАДВАРЫН ШУУД АЖИГЛАЛТ (DOPS)-ЫН ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

.....он.....сар.....

Суралцагч эмчийн нэр.....

Үнэлэгчийн нэр.....

Сургалт эрхлэх байгууллага:_____ Нэгж:_____ Газар: ☐Клиник
☐Тасаг ☐ЯТТ ☐

Бусад_____ Өвчтөний нас:_____ Өвчтөний хүйс: ☐ эр ☐ эм

Гардан үйлдэл:

1. Урьдчилан сэргийлэх үзлэг хийх
2. Амны гаднах үзлэг хийх
3. Амны дотрох үзлэг хийх
4. Амны зөөлөн эдийн гажиг илрүүлэх үзлэг хийх
5. Шүдний өнгөр тодорхойлох
6. Шүдний өнгөр цэвэрлэх
7. Шүдний чулуу цэвэрлэх
8. Фторын бэлдмэл хэрэглэх
9. Ховил битүүлэгч тавих
10. Цоорлыг илрүүлэх уусмал хэрэглэх
11. Зөөлцийн цахилгаан мэдрэг чанар тодорхойлох
12. Халуун хүйтний сорил тодорхойлох
13. Сувгийн урт тодорхойлох
14. Цоорлыг зогсоох түрхлэг түрхэх
15. Сүүн шүдний цоорлын хөндийг хэлбэржүүлэх
16. Бүрэн хэлбэржээгүй байнгын шүдний цоорлын хөндийг хэлбэржүүлэх
17. Эмчилгээний жийргэвч тавих
18. Тусгаарлах жийргэвч тавих
19. Гласс-иономер цементэн ломбо тавих, өнгөлөх
20. Хуванцар ломбо тавих, өнгөлөх
21. Хуванцар матриц хэрэглэх
22. Метал матриц, матриц баригч хэрэглэх
23. Металл түр бүрээсээр цөгцийг сэргээх
24. Шүдний зөөлц сугалах
25. Шүдний зөөлцийг тайрах
26. Сүүн шүдний суваг өргөсгөх
27. Бүрэн хэлбэржээгүй байнгын шүдний суваг өргөсгөх
28. Хүүхдийн шүдний суваг угаах
29. Хүүхдийн шүдний сувагт эм үлдээх
30. Хүүхдийн шүдэнд түр ломбо тавих
31. Хүүхдийн шүдний түр ломбо авах
32. Үхжүүлэх бэлдмэл шүдэнд тавих
33. Амны салстад хэсгийн эмчилгээ хийх
34. Өнгөц мэдээгүйжүүлэлт хийх
35. Нэвчүүлэх мэдээгүйжүүлэлт хийх
36. Дамжуулах мэдээгүйжүүлэлт хийх
37. Гар угааж, халдваргүйжүүлэх
38. Хагалгааны талбай халдваргүйжүүлэх, тусгаарлах
39. Цэвэр боолт хийх
40. Бохир боолт хийх
41. Өвчний түүх нээх, хөтлөх
42. Шинжилгээний хариу уншиж үнэлэх
43. Хүүхдийн шүд авах
44. Амны хөндийн эрүүл мэндийн боловсрол олгох сургалт явуулах
45. Сургалтын тоног төхөөрөмж ашиглах
46. Сургалтын илтгэл бэлтгэх
47. Шүд угаах арга заах
48. Хүүхдэд шүд болон шүдний эгнээний гажиг үүсгэдэг эрсдэлт хүчин зүйлийг илрүүлэх үзлэг хийх
49. Шүд, шүдний эгнээний гажигийн эмчилгээний авагддаг зэмсгийг арчлах

- 50. Хүүхдэд булчингийн дасгал заах
(миогимнастика)
- 51. Гажигийг оношлох эмнэл зүйн
сорилыг гүйцэтгэх
- 52. Зай хадгалах зэмсэг хийж тааруулах
- 53. Амны гаднах рентген зураг авах
- 54. Амны дотрох рентген зураг авах

Суралцагч эмч өнөөдрийг хүртэл хугацаанд тухайн гардан үйлдлийг хийсэн (.....)

№	Үнэлгээ	Хангалтгүй	Завсрын	Хангалттай	Үнэлгээ өгөх боломжгүй
1	Хийх гэж буй үйлдлээ өвчтөнд тайлбарладаг, өвчтөнөөс зөвшөөрлийн хуудас авдаг				
2	Гардан үйлдэл хийх бэлтгэлийг зохистой хангадаг				
3	Халдваргүйжүүлэх үйлдлийг гүйцэтгэдэг, багаж хэрэгслийг аюулгүй хэрэглэдэг				
4	Арга зүйг стандарт удирдамжийн дагуу чадварлаг гүйцэтгэдэг				
5	Өөрийн чадахгүй үйлдлийг ойлгож, шаардлагатай үед тусламж дууддаг				
6	Үйлдлийн дараа багаж хэрэгслийг цэвэрлэдэг				
7	Шаардлагатай бичиг баримтыг гүйцэд бичдэг				
8	Гардан үйлдэл хийх ерөнхий чадвар				

Зөвлөмж:

Сайн тал:

Сайжруулах тал:

Бусад санал:

Үнэлэгчийн гарын үсэг.....

Суралцагчийн гарын үсэг

НОМ ЗҮЙ

1. Акасака.М, Нишино.М бусад “Хүүхдийн нүүр ам судлал”. Улаанбаатар 2009, 2019
2. Jimmy R.Pinkham “Pediatric Dentistry ” 2005
3. О.О.Янушевича, Л.П.Кисельниковой, О.З.Топольницкого. “Детская стоматология”. Москва 2017

4. Angus C Cameron, Richard P Widmer "Handbook of Pediatric dentistry" Toronto, 2003
5. Mc Donald, Avery, Dean "Dentistry for the child and adolescent" 2000
6. Hardy Limeback. Comprehensive Preventive Dentistry. 2012
7. Louis R.Ripa, James A. Barenie "Management of dental behavior in children" USA 1997
8. Andlaw R.J, Rock W.P "A manual of paedodontics" USA 1993
9. Е.В.Боровский "Терапевтическая стоматология" М.М 1987,1998, 2003
10. Е.В.Боровский, В.Н.Копейкин, А.А.Колесов, А.Г.Шаргородский "Стоматология" М.М 1989
11. А.А. Колесов "Стоматология детского возраста" М.М.1978
12. Н.В. Курякина "Терапевтическая стоматология детского возраста" Москва 2001
13. Т.Ф.Виноградова "Диспансеризация детей у стоматолога" Москва 1988
14. Т.Ф.Виноградова "Атлас по стоматологическим заболеваниям у детей" Москва 2010
15. Douglas J.S, Morag C. "Medical bacteriology" New York 1990
16. Curzon M.E.J, Roberts .J.F "Kennedy's paediatric operative dentistry " 1996
17. Crispian Scully "Oral and maxillofacial medicine" Toronto, 2004
18. Pitt T.R "Endodontics in clinical practice" USA 2004
19. Kavas H.Thunthy "Dental radiographic diagnosis" 1997
20. E.Lloyd DuBrul "Oral anatomy" 1988
21. Р.Оюунтөгс, Ж.Дэлгэрцэцэг. "Хүүхдийн шүдний өвчний рентген оношилгоо" 2019
22. Р.Оюунтөгс. "Нүүр амны дүрс оношилгоо 1" 2020
23. June Nunn "Disability and Oral care" 2000